

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

Аудиторын хүлээх хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлангууд нь заль мэх эсвэл алдаанаас үүдсэн материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар ул үндэслэлтэй баталгааг олж авах, өөрийн санал дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан гаргах явдал юм. Ул үндэслэлтэй баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудитаар оршин байгаа материаллаг алдаа зөрчил бүрийг ямагт илрүүлнэ гэсэн баталгаа гаргадаггүй. Заль мэх эсвэл алдаанаас шалтгаалан буруу тайлагнал үүсч болох ба тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай юм.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх байр сууринаас хандаж мэрэгжлийн шийдэл гарган ажилласан. Мөн бид:

- ✓ Заль мэх эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг алдаатай илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж, үнэлэн уг эрсдэлд тохирох аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн санал дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой нотолгоог олж авдаг. Заль мэхнээс үүссэн үгсэн хуйвалдах, баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу тайлагнах, дотоод хяналтыг үл ойшоох зэргээс шалтгаалсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлтэй.
- ✓ Компанийн дотоод хяналтын үр ашигт байдлын талаар санал дүгнэлт гаргах зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг боловсруулах зорилгоор аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- ✓ Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, хийсэн тооцоолол болон холбогдох тодруулгын ул үндэстэй байдлыг үнэлдэг.
- ✓ Мөн компанийн тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх чадамжинд мэдэгдэхүйц эргэлзээ төрүүлэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг тодорхойлж, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байдлын суурийг удирдлага зохистойгоор хэрэглэсэн эсэхийг дүгнэдэг. Хэрэв компанийн тасралтгүй байх чадавхид тодорхойгүй байдал байна гэж үзвэл бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл хийсэн тодруулга хангалтгүй байна гэж үзвэл аудитын санал дүгнэлтээ өөрчилдөг. Бидний дүгнэлт нь аудиторын тайлан гаргах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд суурилдаг. Гэхдээ компанийн тасралтгүй байх чадавхид нөлөөлөх нөхцөл байдал, үйл явдал ирээдүйд үүсч болох юм.
- ✓ Санхүүгийн тайлангийн толилуулга, бүтэц, агуулга, тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангууд нь үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол гол ажил гүйлгээ ба үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.
- ✓ Бид аудитын цар хүрээ, хугацаа, аудитын явцад олж илрүүлсэн томоохон чухал асуудлууд болон ажиглагдсан дотоод хяналтын сул талуудын талаар эрх бүхий удирдлагатай харилцдаг.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 95.1 дүгээр зүйлд заасан хуулийн этгээд болох Нэхээсгүй эдлэл ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд зориулж бэлтгэсэн.

ЗАХИРАЛ.МНБ  М.ЭНХЖАРГАЛ

